



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 356

Арвайхээр

Агуулахын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын 2019 оны “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм батлах тухай” 313 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төгрөг сумын нутагт орших “Боржигт” ХХК-ийн МУ-012118 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг хавсралтаар тогтоосугай

2.Агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахын аюулгүйн бүсэд газар олгох төлөвлөлт хийхгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол), холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (Т.Мөнхдорж), Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т Төгрөг сумын Засаг дарга (Б.Батбаяр)-д тус тус даалгасугай.

3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлагын тайланг тогтоосон хугацаанд холбогдох газруудад хүргүүлж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг “Боржигт” ХХК-ийн захирал (Б.Баянмөнх)-д үүрэг болгосугай

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН

011100813

Аймгийн Засаг даргын 2020 оны .08  
дугаар сарын 18-ны өдрийн 1756 дугаар  
захирамжийн хавсралт

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН  
АГУУЛАХЫН БАЙНГЫН БАЙРШИЛ

Цэгийн дугаар	У	Х
1	103° 23' 31.36"	44° 57' 34.48"
2	103° 23' 35.92"	44° 57' 34.47"
3	103° 23' 35.93"	44° 57' 37.71"
4	103° 23' 31.37"	44° 57' 37.72"

-оОо-